

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛААР
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 22 дугаар зүйлийн 22.4, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг баримтлан Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараахь санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэнг дэвшүүлж санал гаргасан болно.


Төсвийн байнгын хорооны даргаар Баттогтохын Чойжилсүрэнг нэр дэвшүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДАРГАЛАГЧ



Д.ТОГТОХСҮРЭН